

## МОНГОЛ, ЯПОНЫ ЗАН ЗАНШЛЫН УЛАМЖЛАЛЫГ ХАРЬЦУУЛАН СУДЛАХ НЬ

*Т.Намжил\**

Эдүгээ Монгол, Японы харилцаа гүнзгийрэн өргөжиж байгаа нөхцөлд Монгол, Японы соёл, түүх, уламжлалын илүү төстэй талыг шинжлэн гаргаж тавих нь шинжлэх ухааны болон практикийн ач холбогдолтой асуудал болж байгааг үндэс болгон бид Монгол, Японы зан заншлын уламжлалыг харьцуулан судлах зорилгыг тавьж байна.

*Их гэр*

Монголын зарим нутаг, Якут /Саха/, Япон зэрэг газруудад Их /том/ гэр гэдэг ойлголтонд өрхийн хүний тоонд зарц, нэгэн гэр /байшин/-т суудаг хүмүүсийг хамааруулдаг байсан. Ямар ч гэсэн Монголын Нууц товчоо бичигдэх үед Их гэр гэдэг ойлголт байжээ./3/

Монголд Их гэр гэгцээдэг авч, ихэвчлэн “Баруун гэр” гэж хүндэтгэн ярьсгаадаг. “Баруун гэр”-т гал голомт, бурхан, онгон шүтээн байдаг.

Японд нэгэн овгийн доторхи /үндсэн/ гэр бүлийг Хонкэ гэдэг. Харин гэрлэсэн ах, эгч, дүү нар нэг гэрт суух нь туйлын ховор байжээ. Энэ нь Их гэрээс бага гэр бүлүүд тусгаарлан үүсдэгтэй холбоотой.

Судалгаанаас үзвэл Якут, Солонгос, Япон, Индианчууд газар нутаг болон эд материалаасаа хамаарч хэлбэр маягийн хувьд монголын гэрээс өөр авч, дөрөв, зургаа, найман талтай байшин-гэр /зарим нь 20-30 метр урттай/ сууцанд хэд хэдэн гэр бүлээрээ амьдарсгааж байжээ.

Японд хоёроос гурван үеэр нэг гэрт амьдрах явдал ер нь элбэг байдаг байсан бололтой.

Их гэр бүл гэдэг нь ази, дорно дахины эшгийн эрхт ёсны дагуу өвөг эцэг, эмэг эх, эцэг эхтэйгээ үр хөвгүүд, ач, жич нь нэгэн гэрт амьдарч ирснийг хэлж болно./7/

Их гэр Монгол болон Японд өөр өөрөөр нэрлэгдэн ирсэн

\* Т.Намжил - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, профессор

ч бүтэц, үйл ажиллагааны чиглэл нь адил байгаа юм.

### Угийн бичиг

Монголчууд өөрсдийн удам угсаа, овгоо мэддэгээрээ гайхагдаж байсан эртний түүхтэй.

Өөрсдийн овог удам залгамжаа үр хүүхэддээ амаар дамжуулахын зэрэгцээ бичгээр уламжлан угийн бичиг хөтөлж, удам угсаагаа мэдүүлдэг.

Монголчууд угийн бичиг хөтлөхдөө:


а/Зургаар үе залгамжийг нь тоймлон үзүүлэх;

б/Түүхчлэн бичих-гэсэн хоёр аргыг хэрэглэж иржээ.

Угийн зургийг дараахь хэлбэрээр үйлддэг уламжлал тогтож байжээ. Тухайлбал,

-Цаас буюу маажиндсан даавуун дээр хүний үе бүрийг шулуун шугамаар зааглан, дээрээс нь доош цувруулан байрлуулж, овог, нэрийг бичдэг. Энэ нь халх, ойрадал голлон хэрэглэгддэг байна.

-Маажиндсан том даавуу эсвэл цаасан дээр голд нь тойрог татан өндөр дээд өвөгөө тэмдэглээд модны цагираг мэт гадагшаа томорсон олон тойргуудыг татсаар тойрог бүрт нэг үеийг багтаан төрөл, садангийн нэрийг бичдэг аж. /8/



Сэцэн хан аймгийн засаг Дугарсүрэнгийн хошууны ноёд, тайж нарын гэрийн үеийн бичмэл /1905.9.8/

Угийн зураглалыг модны мөчир, навч мэт салбарлуулан хөтөлдөг байсан болохыг эрдэмтэд илрүүлэн тэмдэглэсэн байдаг. Их төлөв буриад монголд угийн зураглалаа дараахи байдлаар тэмдэглэдэг аж. “Ийм маягаар угийн зураглалыг бусад монголчууд хааяа хөтөлдөг байжээ” /4.55/



Буриадын Хуацайн угийн бичиг

Япончууд угийн бичгээ Какэизү гэж нэрлэдэг.

Самурай нарын үед угийн бичгийг эрчимтэй хөтөлж байжээ. Ялангуяа алдартай, сайн “самуурай” нарын удмыг таслахгүйн тулд угийн бичгийг удам дамжуулан хөтөлжээ.

Эзэн хаан, шөгүн, удам дамжсан самурайн /нэр хүндтэй/ гэр бүлийн угийн бичгийг түүхийн ном, товхимолоос үзвэл дараахь маягаар бичигдэж байсан аж.



Госанжэ хааны үеийн нэр нөлөө бүхий  
самуурай Дочёо овогтны угийн бичиг /14, 143/

“Самурай”-н үе дамжсан цөөн тооны айл угийн бичгийг хөтөлж байгаа болов уу гэж япон хүмүүс ярьсгаадаг.

Японд угийн бичгийг настайчуудтайгаа хамт амьдардаг айлууд мэддэг. Залуу гэр бүлүүдэд угийн бичгээ чухалчлах нь багасч байгаа бололтой.

Монгол, Японы гэрийн уламжлалд дараахь нийтлэг талууд байна.  
Үүнд:

- Ураг төрлийг зураглалаар харуулдаг,
  - Аль овгийн хэний угийн зураглал болохыг дээд талд бичдэг,
  - Угийн зураглалд орж тэмдэглэгдэж байгаа хүмүүсийн нэрийн дэргэд таних тэмдэг тавьж, бие биеэс нь ялгадаг,
  - Угийн бичгийг үеэр, тэгэхдээ элгийн талыг баримтлан тэмдэглэдэг.
- Угийн бичиг нь аль ч ураг, төрөл садангийнхны нийгмийн болон гэр бүлийн амьдралын түүх болж хойч үеийнхэндээ үлддэг.

### Өв хөрөнгө залгамжлах ёс

Олонхи улс оронд өрхийн тэргүүлэгч нь эр хүн байсаар иржээ.

Азийн орнууд, түүний дотор Солонгос, Япон зэрэг орны гэрийн зан заншлын уламжлалаар ууган хүүг угсаа залгамжлагч гэж үздэг байна. Тиймээс ууган хүү өвөг дээдсээ дурсах угийн бичгийг залгамжлан авдаг аж. Эцэг өвгөдөөсөө үлдсэн эд хөрөнгийг залгамжлахыг нэр хүндийн хэрэг гэж үзцгээдэг.

Хадам ээж нь үе залгамжилж ирсэн бөгж, кимоноогоо бэрдээ өгдөг ёс байна. Бэр нь цааш өвлүүлдэг аж.

Ер нь өв хөрөнгө залгамжлах ёс монголынхтой тун төстэй.

### Өвөг дээдсээ хүндэлдэг нь

Монгол, Японд дэлхийн бусад орнуудын адил эртнээс нааш урт насалсны баярыг хийдэг.

Хоккайдо болон Сахалины хойгийн өмнөт хэсэгт оршиж байгаа Азийн үндэстнүүдийн нэг Айнучууд хүндлэх, мэндлэх ёсны журамтай аж. Хүн айлд очих үедээ хаалганы гадна нь зогсоод / Монгол, Япончуудтай адил/ хоолойгоо засч чимээ өгнө. Эсвэл барьж яваа зүйлээ дуугарган хүн ирж буйгаа тэр айлын хүмүүст мэдэгдэнэ. /12/

Том болсон ах, эгч нар нь аав, ээжийнхээ зааж сургасан зүйлийг дүү нартаа зааж, хэлж өгдөг сайхан уламжлалтай. Ийм ч учраас:

Япон:	“Өвгөдийн үгийг сонс”,
Монгол:	“Ах нь сургаж Дүү нь сонсдог” гэдэг.

*Шинэ оны баяр*

Японы Ошёгацу /цагаан сар/ нь монголчуудын адил эртний уламжлалтай үндэсний том баярын тоонд зүй ёсоор ордог баяр юм. Эзэн хаан нь цагаан сараар бүх ард түмэн, ахмад хүмүүстээ урт удаан наслахыг ерөөж, хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг өгдөг. Энэ нь монголынхтой тун төстэй. Монгол Улсын Төрийн тэргүүн ард түмэндээ хандан үг хэлж, зуугаас дээш хамгийн өндөр настай хүмүүст гарын бэлэг өгдөг.

Баярын өмнөх өдөр, битүүнийг /японоор оомисока гэдэг/ хийдэг. Гэр орон, орчноо цэвэрлэдэг нь Монголд ч, Японд ч муу бүхнийг хөөж, цэвэр ариун байхын билэгдэл болдог гэж үздэг.

Монголчууд бууз, идээ, тарган хонины ууцыг тавьдаг нь мал сүрэг өсөн дэвжээсэй гэсэн утгатай. Идээний дээж сархад, цагаан идээ /цагаалга/-гээр ширээгээ чимдэг.

Японд цагаан будаагаар хийсэн “озооны, осэчирёри” хэмээгдэх хоол, “отосо” архийг гэр бүлээр цуглан идэж, уудаг.

Монголтой адил Шинийн нэгний өдөр настан буурлууд, ахмад хүмүүс, садан төрөл, найз нөхдийнхөөрөө зочилно. Энэ өдөр Монгол, Япон орны аль алинд нь хэрүүл, маргааныг тэвчин цээрлэдэг.

Японы шинэ жил /ошёгацу/ монголчуудын цагаан сартай адил төстэй ч, бас ялгаатай.

*Зүйр цэцэн үг*

Монгол, Япон хоёр орны хувьд адил төстэй тал байдаг боловч газар зүй, уур амьсгал гэх зэрэг шалтгаанаас болж огт адилгүй өөр зүйл ч их байдаг.

Өргөн удам нутагтай, нараар цагаа тодорхойлж, жилийн дөрвөн улиралд малаа даган нүүдэллэдэг Монголчуудын зүйр цэцэн үгэнд мал аж ахуйн сэдэв голлодог.

Жишээлбэл:

Тэжээсэн бяруу тэрэг эвдэх,  
Сайн морь гэгч эмээлдээ биш  
Сайхан зүс гэгч дээлдээ биш,  
Морьгүй хүн мохоо  
Хоньгүй хүн ховдог /2/ гэдэг бол,

Японд монголынхтой ижил утгатай зүйр цэцэн үгийг голлон эрхэлдэг байсан газар тариалантайгаа холбодог. Жишээ нь:

Амтат гуаны үрнээс чэс ургадаггүй  
Боловсорсон будааны түрүү /бусдаасаа/  
Илүү бөхийдөг гэх мэт.

## Бараг ижил зүйр үг олон байна

### Япон

“Морийг унаж үз  
Хүнтэй найзалж үз”

“Хүнийг хорловол  
Цаана нь хоёр нүх”

“Гэмшил нь хойноо”

“Арван хүн арван өнгө”

“Гурвуулаа хэлэлцвэл бүр оновчтой  
санаанд хүрнэ” гэх зэрэг /5/

### Монгол

“Морины сайныг унаж  
Хүний сайныг ханилж”

“Өөдөө хаясан чулуу  
Өөрийн толгой дээр”

“Гэм нь урдаа, гэмшил нь хойноо”

“Хүн болгон адилгүй  
Хүлэг болгон жороогүй”

“Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй”

“Олы санаа  
Оломгүй далай” гэх зэрэг /2/

## ДҮГНЭЛТ

Монгол, Японы ард түмэн нь хэдийгээр газар зүйн хувьд алслагдан оршиж, байнгын харилцаа холбоогүй байсан авч, өнө эртнээс оюун санааны уламжлалын нийтлэг хүрээнд хамрагдаж, харилцан нөлөөлөлтэй байжээ.

Оюун санааны уламжлал бол үндэсний хил заагаар хязгаарлагддаггүй. Ер нь тэгэх ч ёсгүй билээ.

Монгол, Японы ард түмнүүдийн соёл, ёс заншлын судалгааны ач холбогдлыг иргэд, ялангуяа залуу үеийнхнээс түүх, соёл, зан заншлын дэвшилт уламжлалаас харилцан мэдэх, хүндэтгэх, хүмүүнлэг харилцааны арга ухаанд суралцах эрэлт хэрэгцээ нэмэгдсээр байгаагаар тодорхойлж болно.

Бидний судалгаа Монгол, Японы ард түмнүүд угсаа гарлын, түүх, соёлын холбоотойг цаашид тодруулахад шууд биш ч гэсэн нэгэн хүчин зүйл болно гэдэгт найдаж байна.

Энэхүү өгүүллээ Монголын нэрт эрдэмтэн Х.Пэрлээгийн хэлсэн: “Монголчуудын зан заншлын тархац, харилцан холбогдол нь асар өргөн цартай юм байна. Түүнийг хайж мөшгих зам үүдийг хүний нэгэн үед байтугай, хэдэн үед туулан өнгөрөхүйеэ хялбаргүй биз ээ. Тэр зам үүд нээлттэй, эзнээ хүлээсээр байх нь...” гэсэн үгээр төгсгөө.

## ИШЛЭЛ ЗҮҮЛТ

Монгол хэл дээр:

1. Монгол ардын цэцэн үг. УБ. 1989.
2. Монгол зүйр цэцэн үгийн далай. 1966. I, II
3. Монголын нууц товчоо. УБ., 1990.
4. Монгол, Японы түүхэн харилцаа. УБ., 1998.
5. Мөнх наст цэцэг. УБ., 1964. /М.Цэдэндоржийн орчуулга/
6. Т.Намжил. Монгол ба Зүүн хойт Азийн гэр бүл. Дэд дэвтэр. УБ., 2000. ред. Ч.Далай
7. Т.Намжил. Монгол, Өрнө, Дорно: Гэр бүлийн зан заншлын уламжлал, холбоо. УБ., 1999. , III дэвтэр, ред. Ч.Далай
8. А.Очир. Монголчуудын овгийн лавлах. УБ., 1998. Ж.Сэржээ.
9. Б.Сумъяабаатар. Буриадын үгийн бичээс. УБ.1966.

Япон хэл дээр:

10. Нихон-но Кодомо, Хакусё. Токио, 1980. Эгами Намио, Айни-то Кодай Ниппон.
11. Умехара: Такэси, Токио, 1982
12. Камиями харухиро YIII боть
13. "Японы түүх" цуврал. YIII боть